

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.04.25

№ ХТ-22/01

Улаанбаатар хот

Огноо: **2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр**

Цаг: **10:00-12:30**

Хурал болсон газар: **“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн хурлын танхим**

Хурлын дарга: **ГэрэлтТэлмэн /ТУЗ-ийн ердийн гишүүн/**

Хурлын нарын бичгийн дарга: **Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: **31**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: **96,181,814**

Хурлын ирц: **96.6%**

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай,
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсөв батлах тухай,
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай,

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн хурлын танхимд явагдлаа. Хуралд хурлын дарга Г.Тэлмэн, ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, ердийн гишүүн Д.Дэлгэрмаа, Д.Балжинням, Д.Жавхлан, О.Одбаяр, хараат бус гишүүн В.Ганзориг, Б.Ганбаатар, Д.Балдорж, Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар болон компанийн удирдлагын багийн бүрэлдэхүүн биечлэн оролцлоо.

Хурлын бүртгэлийг 10:00 цагт хааж, тооллогын комиссын дарга О.Сарангэрэл хурлын ирцийн мэдээллийг хурлын даргад мэдээлснээр хурал эхэллээ.

Хурлын дарга Г.Тэлмэн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тооллогын комисс ирцийн мэдээллийг танилцуулж, хурлын ирцийн хувь хүчин төгөлдөр болсон тул “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа эхэлье. “Монгол шуудан” ХК сүүлийн 2 жил цахимаар хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийсэн. Ковидын нөхцөл байдал сайжирч энэ жил биетээр цуглан та бүхэнтэйгээ уулзаж, хурлаа хийх болсонд компанийн ТУЗ, удирдлагын багийн нэрийн өмнөөс баяртай байна. Та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя.

- Хурлын дарга Г.Тэлмэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг танилцууллаа.

Хурлын дарга Г.Тэлмэн: Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал 1-тэй холбоотой танилцуулгуудыг хийе.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;**

Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар: Эрхэм хүндэт “Монгол шуудан” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жил тээвэр, логистик гээд бүхий л салбарт хямралууд үүссэн. Одоо ч гэсэн тодорхой хэмжээний хязгаарлалтууд хэвээр байна. Цаашид цар тахлын нөхцөл байдал ямар хэмжээнд хүрэхийг тааварлах боломжгүй байна. Компанийн хувьд хорио цээр

тогтсон энэ 2 жилийн хугацаанд бүх нийтийн үйлчилгээний үүргийг биелүүлж, үйл ажиллагаагаа тасралгүй явуулж ирлээ.

- “Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар компанийн 2021 оны тайланг дэлгэрэнгүйгээр танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

Хурлын дарга Г.Тэлмэн: Гүйцэтгэх захирал Б.Анхбаатарт баярлалаа. Өнгөрсөн жилийн эхний хагаст хатуу хөл хориотой байсан. Компанийн хувьд хэрэглэгчид, ард иргэдэд шуудангаар дамжуулан үйлчилгээ авах боломжийг хангаж ажилласан. Нэлээд сорилттой тулгарсан. Санхүүгийн байдал хүнд гарах болов уу гэж бодож байсан боловч боломжийн үр дүнтэй гарсан. Дараагийн танилцуулга хийх гишүүнийг урья.

ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг В.Ганзориг гэдэг. Аудитын хорооны гишүүнээр ажилладаг. Та бүхэнд Аудитын хорооны дүгнэлтийг танилцуулъя. Юуны өмнө өнгөрсөн хүнд хэцүү нөхцөлд компаниа удирдаж ажилласан гүйцэтгэх удирдлагын багт баяр хүргэе.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын хорооны дүгнэлтийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

Хурлын дарга Г.Тэлмэн: Хараат бус гишүүн В.Ганзоригт баярлалаа. Танилцуулгууд бүрэн явж дууссаны дараа асуулт, хариулт руугаа оръё. Дараагийн танилцуулгыг хийнэ үү гэж хараат бус гишүүн Б.Ганбаатарыг урья.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар: Юуны өмнө та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Б.Ганбаатар гэдэг. ТУЗ-ийн шийдвэрийн дагуу компанийн ногдол ашгийн тайлан танилцуулъя.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар компанийн 2020 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар: Хараат бус гишүүд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж ажилладаг. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд бүх хараат бус гишүүд орж ажилладаг. Компанийн хувьд цаашдаа ногдол ашгийн хэмжээ өсөх хандлагатай юм байна гэж харж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын байдал удахгүй намжих байх. Тэгвэл өмнөх бизнесийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, цэвэр ашгийн хэмжээ өсөх хэд хэдэн үнэт зүйлүүд байна гэж ойлгож байгаа. 100 жилийн түүхтэй цөөхөн хэдэн компанийн нэг нь “Монгол шуудан” ХК юм. Компанийн хувьд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж чадах салбар, нэгжтэй, бизнесийн үйл ажиллагааг явуулж болох таатай нөхцөлүүдтэй. Монгол улсын соёлыг түгээж байдаг үнэт зүйл болох Монгол маркийн фонд байдаг. Эдгээр хүчин зүйлүүд нь ирээдүйд хувьцаа эзэмшигчиддээ ашигтай нөлөөлж, та бүхний нэгж хувьцаанд ногдох хувь хэмжээ ихсэх байх гэсэн өөдрөг сэтгэлтэй байна. Өнөөдрийн энэ хурлын индэр дээрээс компанийн нийт албан хаагч, удирдлагын багт баяр хүргэх ёстой гэж үзэж байна. Ковидын хамгийн хүнд нөхцөлүүдэд шуудангийн ажилтан албан хаагчид нэг ч өдөр зогсохгүйгээр ажиллаж байсан. Компанийн цаашдын үйл хэрэг, бизнесын үйл ажиллагаанд хараат бус гишүүнийхээ үүргийн дагуу идэвх зүтгэлтэй ажиллана. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Хурлын дарга Г.Тэлмэн: Б.Ганбаатар гишүүнд баярлалаа. Компани 2016 онд 34 хувийг олон нийтийн эзэмшилд хувьчилж гаргаснаас хойш 6 дахь жилдээ ногдол ашиг тасралтгүй тараахаар болж байна. Өнгөрсөн 2020 онтой харьцуулахад цэвэр ашиг буурсан ч гэсэн 2021 онын цэвэр ашгаас 50 хувиар тооцож ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан нь нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг 2 төгрөг болж өссөн. Цаашдаа амжилттай ажиллахыг хүсье. ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл таныг дэгийн дагуу дараагийн танилцуулгыг хийнэ үү хэмээн урья.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд идэвхтэй оролцож байгаа эрхэм хувьцаа эзэмшигч нартаа талархсанаа илэрхийлье.

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл ТУЗ-ийн 2021 оны тайлан дүгнэлтийг танилцууллаа.  
/Танилцуулгыг хавсаргав/

Хурлын дарга Г.Тэлмэн: ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл танд баярлалаа. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор 11:15 цаг хүртэл асуулт байвал авъя. Үүнээс өмнө нэг мэдээлэл хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаад, үнэт цаасны компаниудаар дамжуулаад 03 дугаар сарын 25-аас эхлэн материалууд, саналын хуудаснуудыг тараасан байгаа. Урьдчилсан санал хураалт 03 дугаар сарын 25-аас 04 дүгээр сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл авахаар зохицуулагдсан. Өнөөдөр хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид маань санал хураалтыг нэгтгэх, завсарлага хүртэл 3 асуудлын хүрээнд саналаа өгөх боломжтой байгаа. 3-р асуудал нь кумулятив аргаар саналаа өгдөг. Заавар, тусламж хэрэгтэй бол тооллогын комиссын гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас асуух боломжтой. Асуулт хариултын цагийг авъя. Компанийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар, ТУЗ-ийн дарга, гишүүд болон удирдлагын багийн бүрэлдэхүүн бүгд ирсэн байна. Та бүхэн бас нэр цохоод асуултуудаа чөлөөтэй асууж болно.

Гаули инвестмэнт ХХК-ийн Мөнхгэрэл: 1. Стратегийн хөрөнгө оруулалт буюу ОУ-ын ялган боловсруулах төв барих ажил 4 тэрбум гэж ярьсан. Энэ хөрөнгө оруулалтыг хийснээр хэдий хэмжээний ашиг олно гэж хүлээж байгаа вэ? Тооцоолол, дэлгэрэнгүй тайлбар байгаа юу? 2. Компанийн 2021 оны зорилтот түвшин 110 хувийн өсөлттэй гэсэн байна. Тайлангаас харахаар татварын дараах цэвэр ашиг 400 сая төгрөг байна. Зорилтот түвшингийн төлөвлөгөө авахдаа багаар авсан юм уу? Сүүлийн 3 жилийн байдлаас харахад дандаа бууралттай явж байна.

Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар: 2016 онд компанийн 34 хувийг хөрөнгийн биржид гаргасан. Эндээс 6.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Тэр үед компанийн хувьд Улс хоорондын шуудангийн үйл ажиллагааг өргөтгөх, хил дамнасан и-худалдаа буюу транзит шуудангийн үйлчилгээ дээр илүү анхаарч ажиллаж ирсэн. Иймээс энэ татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Улс хоорондын шуудан ялган боловсруулах төв барих төсөл боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж батлуулсан. Тэр үед Хөшигийн хөндийд шинэ нисэх онгоцны буудал баригдах ажил яригдаж эхэлсэн байсан тул бид тэнд ялган ялган боловсруулах төвөө барихаар төлөвлөж газрын асуудлыг хөөцөлдөж эхэлсэн. 2 жил гаруй хугацаанд газрын асуудлыг хөөцөлдөж байж 2019 оны сүүлээр 5,200 м2 газрыг “Монгол шуудан” ХК-ийн нэр дээр авсан. Улс хоорондын шуудангийн үйлчилгээг өргөжүүлэх нь компанийн хамгийн том стратеги зорилтын нэг. Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал нь Ази дахь дамжин өнгөрөх бүс болох стратегийн том зорилттой байгаа юм байна. Иймээс бүс нутгийг хамарсан транзит шуудангийн үйлчилгээг нисэх буудлаар дамжуулж үзүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх гэсэн том зорилт тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар Улс хоорондын шуудангаас 6 тэрбум орлого олдог. Энэ орлогыг цаашид нэмэгдүүлэх зорилготой. 2-р асуудлын хувьд: ТУЗ-өөс баталж өгсөн төлөвлөгөөний дагуу ажилладаг. 2021 оны хувьд нэлээд сорилттой жил байсан. Олон улсын шуудангийн үйлчилгээ буюу орох шуудан бүр зогссон.

Хурлын дарга Г.Тэлмэн: Б.Анхбаатар захиралд баярлалаа. Ялган боловсруулах төвийн ажил маань нөхцөл байдлаас шалтгаалаад хойшилсон байж байгаад эхэлсэн. Олон улсын нислэгүүдтэй холбоотой байгаа учраас компанийн зүгээс эдийн засгийн үр ашгийн тооцооллыг дахин хийх шаардлага үүсэж байгаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: 2 дахь асуудал дээр нэмэлт тайлбар хэлье. Олон улсын нислэгүүд зогссонтой холбоотойгоор орох шуудан зогссон. Энэ нь нэлээд олон тэрбум төгрөгийн орлогын тасалдал үүсгэх нөхцөл бүрдсэн. Иймээс ТУЗ-өөс 2021 оны бизнес төлөвлөгөөг нөхцөл байдлыг харгалзан үзэж баталж өгсөн. Нөхцөл байдал сайжрах болов уу гэж харж байсан боловч хил

хаагдсанаас болж транзит шуудангийн үйлчилгээ мөн хүндрэлтэй болж ирсэн. Гэвч компани боломжуудаа ашиглаж сайн ажиллаж чадсанаар төлөвлөгөөний гүйцэтгэлийг өсөлттэй гаргаж чадсан байгаа.

Хувьцаа эзэмшигч иргэн Б.Цэрэнжав: 1-рт: Төрийн өмчийн хувийг багасгах ойрын болон алсын ирээдүйн төлөвлөгөө байна уу? Төр хувийн хэвшлийн үлгэр жишээ компани гэж ярьдаг. Энэ дагуу төрийн хувийг багасгах эрмэлзэл байна уу? 2-рт: Шуудан буюу ТУЗ-д логиستيкийн компанийн төлөөлөл бага байна. ТУЗ-ийн гишүүд сар болгон 1.0-1.2 сая төгрөгийн цалин авдаг юм байна. Төрийн алба хааж байгаа хүмүүс үндсэн цалингаа авч байгаа гэж бодож байгаа. Дээр нь сар болгон сая төгрөгийн цалин авдаг. Ганц жишээ Д.Нарангэрэл даргаас асууя. Та төрийн алба хаагаад хэдэн төгрөгийн цалин авдаг вэ? Хэдэн төрийн компанийн ТУЗ-д төлөөлөл хийдэг вэ? Таны хувийн орон зай руу ороод асуучих шиг боллоо. Эцэст нь хэлэхэд жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж байна. Гэтэл бид жил болгон олон жилийн өмнө байгуулагдсан улаан буландаа хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээд байх юм уу? Хувьцаа эзэмшигчдийн хурал жилд нэг удаа хуралддаг. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн баяр байх ёстой гэж харж байна. Иймээс энэ хэв маягаа өөрчлөх болоогүй юу?

Хурлын дарга Г.Тэлмэн: Хувьцаа эзэмшигч Б.Цэрэнжав танд баярлалаа. Эхний асуудлыг ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэлийг хариулах байх гэж бодож байна. Мөн өнгөрсөн 6 жилийн хугацаанд хувийн хэвслээс орж ажилласан О.Одбаяр гишүүнийг өөрийн санал бодлоо хэлсэн асуудлууд дээр хуваалцана уу гэж хүсэж байна. Бидний хэлэлцэх асуудлын 2-т ТУЗ-ийн зардлын төсөв яригдана. Тэнд цалингийн талаар хариулт хэлчиж болох болов уу гэж харж байна. Хурлын дэгийг ТУЗ-өөс баталсан. Д.Нарангэрэл даргад хандаж асуусан асуудал дээр хурлын даргын хувьд хэлэхэд хэлэлцэх асуудалтай холбоогүй асуудлаар хариулт өгөхгүй байж болно. Хурлын зохион байгуулахтай холбоотой асуудал дээр хувьцаа эзэмшигчдийн төлөөлөн ТУЗ-ийн гишүүдээс хариулна гэж бодож байна.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Төрийн өмчит компанийг өөрчлөн байгуулах, хувьчлах үндсэн чиглэлийг өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Улсын Их хурал үндсэн чиглэлээрээ баталдаг. Үндсэн чиглэлд нийцүүлж, Засгийн газраас хувьчлах, өөрчлөн байгуулах хөтөлбөрийг баталдаг. Энэ хөтөлбөр батлагдсаны дараа тэр үндсэн чиглэл хөтөлбөрт худалдах, хувьчлахаар орсон тохиолдолд тэр шийдвэрүүд хэрэгждэг. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хувьчлах асуудал яригдахгүй. Төр өөрөө төрийн өмчтэй компанийн хувьцаа эзэмшигч болохын тулд худалдах, хувьчлах асуудал нь бүгд Их хурал, Засгийн газрын шийдвэрээр явдаг. Өнөөдрийн байдлаар Засгийн газраас төрийн өмчтэй компаниудын үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой багц асуудлууд, хуулийн төсөл хэлэлцэгдэхээр явж байгаа. "Монгол шуудан" ХК-тай холбоотой одоогоор гарсан төрийн хувийг багасгах шийдвэр байхгүй байна. Хэрэв энэ талаар хэлэлцэхээр бол Их хурлаар орох тул ард иргэдэд нээлттэй, ямар арга замаар, ямар шийдвэрээр нэмж хувьцаа гаргах вэ гэсэн асуудлууд яригдах байх. Тэр үед нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл олж авах боломжтой гэж бодож байна. ТУЗ-д төрийг төлөөлж томилогдсон гишүүд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу төрийн тангараг өргөсөн тодорхой шаардлага хангасан жинхэнэ албан хаагчид томилогддог. 2016 оноос хойш "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс ТУЗ-д ажиллах хүмүүсийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлэдэг. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хуралдаанд төрийн нарийн бичгийн дарга нар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга гээд 9 хүний бүрэлдэхүүнтэй гишүүдээс бүрэлдсэн хуралдаан байдаг. Энэ хуралдаанаар Төрийн өмчтэй компаниудын ТУЗ-д ямар хүмүүсийг томилох, ямар үүрэг хариуцлагатай оролцох талаарх асуудлуудыг шийддэг. Хараат бус гишүүнийг компани сонгон шалгаруулалтын журмаар сонгодог.

ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие жижиг хувьцаа эзэмшигчид болон Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг төлөөлж ТУЗ-д гишүүнээр ажилладаг. Иймээс

жижиг хувьцаа эзэмшигчиддээ тодорхой мэдээлэл өгье гэж бодож байна. Түрүүний залуугийн асуусан асуултын дагуу яагаад ашиг ингэж улам буураад байна вэ гэдэг асуудлыг ТУЗ-ийн гишүүний хувьд компанийн удирдлагад байнга хэлдэг. Компани хувьчлагдаад 6 жил боллоо. Төр хувийн хэвшлийн хамтарсан хамгийн үлгэр жишээ компани гэдэг боловч өнөөдөр 6 жилийн үзүүлэлтийг харахад компанийн орлого ашиг сүүлийн 3 жил буурсан үзүүлэлттэй байгаа. Нөхцөл байдлыг харгалзаж үзээд эцэслээд тооцоо гэхэд 2020 онд 500 гаруй сая төгрөг байсан, 2021 онд 400 сая төгрөг болсон. Төлөвлөгөөгөө буулгаж батлаад түүнийгээ давуулаад биелүүлчихсэн байна гэдэг асуудлыг энэ залуу зөв харж гаргаж ирлээ. Бид 2022 оны бизнес төлөвлөгөөг 1 тэрбум төгрөг болгож өсгөсөн. Миний бие өөрийн санаа бодлоо хэлсэн. Дараагийн нэг асуудал бол энд байгаа хувьцаа эзэмшигчид төрөөс 34 хувийг худалдан авч 6.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн. Үүгээр юу хийв гэхээр авто паркийн шинэчлэлт дээр тодорхой хөрөнгө оруулалт хийсэн. Мөн шинэ нисэх онгоцны буудлын хажууд ялган боловсруулах төвийг барьж байна. Бидний мөнгө удахгүй дуусна. Цаашид яах вэ гэдэг тухай компанийн удирдлагад хэлж байгаа. Бид дахиад хөрөнгө оруулах уу, эсвэл хувьцаа эзэмшигчдийн хэлснээр улаан буландаа хуралдаад байх уу гэдэг асуудлыг хөндөж тавьж байгаа. Бидэнд маш олон өрсөлдөгчид гарч ирж байгаа. Цар тахлын үед дотоодын логистикийн тээвэр, хүргэлтийн зах зээл нэмэгдсэн. Хүргэлтийн компаниуд ашиг орлоготой ажилласан. Иймээс бид энэ зах зээлдээ хэрхэн өрсөлдөх вэ, ашиг орлогоо яаж нэмэгдүүлэх вэ гэх мэт дунд хугацааны стратеги төлөвлөгөө дээр хамтарч ажиллах саналыг тавиад байгаа. Хувьцааны асуудлыг ярьж байна. Төрийн 66, хувийн 34 гэдэг миний хувьд буруу гэж үзэж байгаа. Энэ компанийг хөгжүүлэе гэвэл илүү олон нийтийн компани болгож, нийтийн эзэмшлийг нь илүү болгож, засаглалыг нь илүү сайжруулах юм бол компани цаашаа хөгжинө. Төр гэдэг ард иргэдийн өмнөөс шийдвэр гаргаж байгаа байгууллага. Төрийн ард иргэд байгаа. Бид нэмж хувьчлах асуудлыг байнга хөндөж ярьдаг. 34 хувь дээр бидэнд боломжтой хэмжээний ашиг ирэхгүй байгаа. Аль болох 51-ээс дээш хувь олон нийтэд хувьчлавал энэ компанид илүү их үр өгөөжтэй болов уу гэж бодож байна. Цаашлаад төр хувийн хэвшил 2 нийлээд хөрөнгө оруулалт хийе гэсэн саналыг мөн хэлсэн. Хувьцаа эзэмшигчдээс гарсан асуудлын дагуу шаардлагыг тавьж байгаа шүү гэдгээ та бүхэнд хэлье. Төр энэ тал дээр анхаарал хандуулж байх шиг байна. Төрийн компаниудыг хувьчлая, олон нийтийнх болгоё гэсэн шийдвэрүүд гаргаад явж байна. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн зүгээс үйлчилгээг нь цааш нь нэмэгдүүлэе, сайжруулъя, хөрөнгө оруулъя гэсэн санал тавиад байгаа. 6 жилийн өмнө 6 тэрбум төгрөгөөр авчхаад жилдээ 400 саяын ашиг хуваагаад манайд оногдож байгаа нь 60 сая төгрөг л байна. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ард 10 мянган хувьцаа эзэмшигч байдаг. 60 сая төгрөгөөр бид юу хийх вэ? Энэ мэт асуудлыг ТУЗ-ийн хурал дээрээ бид нээлттэй ярьж ажиллаж байгаа шүү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хурлын дарга Г.Тэлмэн: Баярлалаа. Төрийг төлөөлж байгаа ТУЗ-ийн дарга, гишүүд болон жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллүүд бүх асуудлууд дээр 100 хувь дэмжээд явдаггүй. Бид мэтгэж, маргаж, зөв шийдлийг эрэлхийл ажилладаг. Зөв зүйтэй зүйл дээр саналаа нэгтгэж ажиллаж байгаа шүү гэдгийг энэ байр сууринаас харсан болов уу гэж бодож байна. Өөр санал хүсэлт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалд оръё.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудалд орлоо.

#### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: ТУЗ-ийн 2022 оны зардлын төсөв батлах тухай;**

Хурлын дарга Г.Тэлмэн: ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооны даргыг урья.

- ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга Д.Дэлгэрмаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

ЗНДЦУХ-ны дарга Д.Дэлгэрмаа: Өмнөх асуудал дээр хувьцаа эзэмшигчийн асуусан асуултад хариулъя. ТУЗ-ийн гишүүний цалин хөлс өмнөх оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан

дүнгээр явж байгаа. Компани 66 хувийн төрийн өмчийн оролцоотой. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар эрх зүйн харьцааг нь зохицуулж явдаг. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалтад оролцоотой компанийн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүн томилох шаардлагыг зааж өгсөн байдаг. Төрийн захиргааны албан хаагч болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа байгууллагын ажилтан байна гээд тодорхой заагаад өгсөн. "Монгол шуудан" ХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлнэ гээд Засгийн газар 2016 оны 80 дугаар тогтоолоор заасан байдаг. Ийм учраас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Д.Нарангэрэл дарга, Д.Дэлгэрмаа миний бие төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлээд ажиллаж байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг дээр "Төлөөлөл удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч нь эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно." гэж заасан байгаа. Компанийн хувьд эрх бүхий байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байдаг. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд "Компанийн эрх барих дээд байгууллага хувьцаа эзэмшигчдийн хурал байна.", 75 дугаар зүйлд "Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна." гэсэн заалтууд байдаг. Иймээс 62 дугаар зүйлийн 1.13 дээр заасанчлан ТУЗ-ийн цалин урамшууллын хэмжээг тогтоож өгдөг. Энэ бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсийг батлуулсан байгаа. Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудаар ТУЗ хариуцлагатай шийдвэрүүдийг гаргаж явдаг. Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл дээр Компанийн ТУЗ-ийн гишүүн бол компанийн эрх бүхий албан тушаалтан гэж тооцогдож явдаг. Эрх бүхий албан тушаалтны гаргасан буруутай шийдвэрийн улмаас компанид хохирол учрах юм бол эрх бүхий албан тушаалтан өөрийн хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг байгаа. Хариуцлагатай шийдвэр гаргасныхаа төлөө өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээж байгаа учраас сард тодорхой хэмжээний цалин хөлс авах эрх зүйн зохицуулалтууд нь хууль дээр бүрэн байна. Иймээс та бүхэн ойлгож хүлээн аваарай. Баярлалаа.

Хурлын дарга Г.Тэлмэн: Д.Дэлгэрмаа гишүүнд баярлалаа. Өөр асуулт байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудал 2-ийг үүгээр хаая.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай;**

Хурлын дарга Г.Тэлмэн: ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл таныг индэрт урьж байна.

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулгыг хийв. /Танилцуулгыг хавсаргав/

Хурлын дарга Г.Тэлмэн: Асуулт хариултын цагийг авъя. Нэр дэвшигчдээс асуулт асууж болно.

Ардын тэтгэврийн данс ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга: Компаниа төлөөлж хуралд оролцож байна. Хараат бус гишүүн дээр нэр дэвшсэн 3 хүн л байна. ТУЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооноос багадаа 4 юм уу 5 хүн нэр дэвшүүлж болоогүй юм уу? Дараа дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал дээр анхаарч ажиллавал зүгээр байна. Өнгөрсөн жил ашиг 400 сая. ТУЗ-ийн төсөв өөрөө 155 сая гэхээр хувьцаа эзэмшигчдийнхээ авах ашгаасаа 30 гаруй хувь болоод байна. Иргэдэд очиж байгаа ашгийн хувь нь бага байгаад байна. Иргэдэд очиж байгаа ашгийн түвшинтэй уялдуулж ТУЗ-ийн зардлыг жилийнхээ төлөвлөгөөнд оруулж өгвөл зүгээр болов уу гэсэн саналтай байна.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн хувьд өнгөрсөн жил 2 жилийн хугацаагаар томилсон. Гэвч ТУЗ-д төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй 2 гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон. Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг кумулятив аргаар сонгож байгаа. Кумулятив аргаар сонгосон тохиолдолд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусаагүй боловч бүрэлдэхүүнд өөрчлөлт ороход ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дахин сонгохоор зохицуулалт байдаг. Энэ дагуу ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг дахин нэр дэвшүүлж

сонгож байгаа. Иймээс энэ жил хараат бус гишүүн дээр сонгон шалгаруулалт зарлаагүй. Дараа дараагийн хурлууд дээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусаад сонгон шалгаруулалт явуулах үед олон нэр дэвшигчидтэйгээр оруулж ирэх боломж бол байгаа. Дараа дараагийн хурлууд дээр энийг анхааръя. Хувьцаа эзэмшигчийн саналыг хүлээн авлаа.

Хурлын дарга Г.Тэлмэн: Хэдийгээр хурал даргалж байгаа ч гэсэн 2 дахь асуултад товч хариулья. Ашигт ажиллагааг ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулалтай уялдуулж болохгүй юу гэсэн асуулт байна гэж ойлгосон. "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн нь нэг сая төгрөг, хороон дарга нь сая нэг зуу, ТУЗ-ийн дарга нь нэг сая хоёр зуу. Монгол улсын цалингийн системээр дундаж цалинтай харьцуулахад энэ нь төдийлөн өндөр цалин гэж харахгүй байгаа. Нэг мянга гаруй ажилтантай, хариуцлагын хувьд, ТУЗ-өөс гаргадаг шийдвэрүүдийн хувьд энэ нь бага. Ашигт ажиллагаа тал дээр бид ТУЗ-ийн хурал дээрээ байнга ярилцдаг. Бид өөрчлөлтийг хийж эхэлж байгаа. Гүйцэтгэх захирлын ажлыг дүгнэдэг шалгуур үзүүлэлт нь 2017 онд батлагдсан загвараараа явж байсан. Бид үүнийг өөрчилж байгаа. Ялангуяа 2022 оны шалгуур үзүүлэлтүүд дээр ашигт ажиллагаа дээр илүү анхаарал тавьж, санхүүгийн үзүүлэлт дээр нь оруулж өгсөн. Тэр дундаа өөрийн хөрөнгийн өгөөж, нийт хөрөнгийн өгөөж гэдэг зүйлүүд дээр нэлээд ач холбогдол өгч шалгуур үзүүлэлтүүдийг өмнөх жилийнхээс илүү сайн ашигт ажиллагаа руу чиглүүлэх тал руу оруулж өгсөн. Үүний үр дүн 2022 ондоо гарах болов уу гэж найдаж байна. Өөр асуулт байна уу? Асуулт байхгүй бол хэлэлцэх асуудлыг үүгээр хаагаад санал хураалт нэгтгэх завсарлага зарлаж байна. 12:10 цагт эргээд энэ танхимдаа уулзаад тооллогын комиссын санал хураалтын дүнгийн тухай тогтоол болон хурлаас гарах шийдвэрийг та бүхэнд танилцуулах болно.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дээрх хэлэлцсэн асуудлуудын санал хураалтын ажиллагаанд орлоо. Хурлын завсарлага 12:10 цагт дуусаж хурлаа үргэлжлүүлээ.

Хурлын дарга Г.Тэлмэн: Тооллогын комиссыг санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын тогтоолыг танилцуулахыг хүсье.

- Санал хураалтын дүнг нэгтгэж дууссан тул Тооллогын комиссын гишүүн тоологын комиссын тогтоолыг танилцуулж, хурлын даргад хүргүүлээ. Мөн хурлын дэгийн дагуу "Монгол шуудан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг хурлын дарга Г.Тэлмэн танилцууллаа.

Хурлын дарга Г.Тэлмэн: Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа оролцсон нийт хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлууд бүгд хэлэлцэгдэж, танилцуулагдаж, санал өгч, бас хэлэлцсэн асуудлууд бүгд батлагдаж дууслаа. Хурлыг хааж товчхон хэдэн зүйл хэлье. Хурлын явцад жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс зөв зүйтэй саналууд хэлж байна. Анх 2016 оны 01 дүгээр сарын 09-нд "Монгол шуудан" ХК-ийн 34 хувийг олон нийтийн болгож, Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалснаас хойш өдгөө 6 дахь жилтэйгээ золгож байна. Анх энэ хувьчлалд 185 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож байсан бол өнөөдөр "Монгол шуудан" ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 2900 буюу 20 дахин өссөн үзүүлэлттэй явж байна. Өнгөрсөн 6 жилийн хугацаанд гаргасан амжилтууд их бий. Амжуулж хараахан чадаагүй зүйлсүүд ч бий. Та бүхэн яг энэ цаг мөчид Монгол улсын Засгийн газраас төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит үйлдвэрийн газруудыг дараагийн олон нийтийн хяналтад оруулах асуудал яригдсаныг дуулсан байх. Хэвлэл мэдээллийн байгууллагуудаар жагсаалт нь гарсан байсан. "Монгол шуудан" ХК нь яах аргагүй эдгээр компаниудын үлгэр жишээ болж, өнгөрсөн 6 жилд олсон, алдсан зүйлсийг нь харж энэ үйл ажиллагааг Засгийн газраас хэрэгжүүлж байгаа байх гэж ойлгож байгаа. Саяхан Монголын эдийн засгийн форум болсон. Энэ форумд "Монгол шуудан" ХК болон хувьцаа эзэмшигчид оролцож өөрсдийн байр сууриа илэрхийлж, саналуудаа хэлсэн. "Монгол шуудан" ХК нь 6 дахь жилдээ хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг амжилттай хийлээ. Ковидын нөхцөл байдлын дараа буюу 2 жилийн дараа нийт хувьцаа эзэмшигчидтэйгээ уулзлаа. Мэдээж шүүмжлэлтэй зүйлсүүд

хурал даргалагчийн хувьд байна. Жижиг хувьцаа эзэмшигч саналаа хэлж байсан. Хувьцаа эзэмшигчдийн баяр байх ёстой гэж. 2900 хувьцаа эзэмшигчидтэй болсон байгууллага өмнөх жишгээрээ жижиг хурлын өрөөнд ингэж хийж болохгүй юм байна гэдгийг Гүйцэтгэх захирал, компанийн удирдлагууд анхаарч ажиллана гэдэгт найдаж байна. Өнөөдөр цаг зав гаргаж, "Монгол шуудан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд хариуцлагатайгаар оролцож, саналаа өгч, санал бодлоо хуваалцсан та бүхэнд маш их баярлалаа. Цаашдаа ТУЗ та бүхнийг төлөөлж, "Монгол шуудан" ХК-ийн дараагийн 6, 10 жилийн хөгжилд хувь нэмрээ оруулан хичээн ажиллах болно гэдгээ нийт ТУЗ-ийн гишүүдийн өмнөөс хэлмээр байна. Нийт хувьцаа эзэмшигчиддээ ашиг орлого, өгөөж нь өндөр байх болтугай гэж ерөөе. "Монгол шуудан" ХК-ийн удирдлагын баг, нийт ажилтан албан хаагчдад компанийнхаа өсөлтийг хангаж, 21 дүгээр зууны орчин үеийн шуудан болоход түүчээлж ажиллах болтугай гэж ерөөе. Дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар уулзталаа түр баяртай. Хурал хаасныг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.

Энэ удаагийн хурал 12:30 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



Г.ТЭЛМЭН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.ЦЭЦГЭЭ